


1. Зүрхний хоёр ба гурван хавтаст хавхлагийг үүргийг сонгоно уу.
 А. Зүрхийг баруун, зүүн гэсэн хоёр хэсэгт хуваана.
 Б. Зүрхний ховдол, тосгуурыг зааглан, цусыг нэг чигт урсгана.
 В. Зүрхний бүлчинг хүчилтөрөгч болон шим бодисоор хангах
 Г. Зүрхний бүлчинг агшаах цахилгаан сэрэл үүсгэх
2. Тал саран хавхлаг хаана байдаг вэ?
 А. Зүрхний ховдол, тосгуурын хооронд
 Б. Зүрхний баруун, зүүн ховдлоос гол судас болон уушигны артери луу гарсан хэсэгт
 В. Зүрхний баруун, зүүн талын хооронд
 Г. Зүрхний синусын зангилаанд
3. Синусын зангилаа буюу пэйсмакер гэж юу вэ?
 А. Зүрхний баруун тосгуурын дээд хэсэгт байрлах, цахилгаан сэрэл үүсдэг бүлэг эсүүд
 Б. Зүрхний цохилтын тоонд нөлөөлөх гормон
 В. Зүрхний нэг удаагийн агшилтын эхнээс дараагийн агшилтын эхлэл хүртлэх үе
 Г. Зүрхний бүлчин сулран, цусаар дүүрэх үе
4. Тал саран хавхлаг хэзээ хаалттай байдаг вэ?
 А. Ховдлын систолын хувьд
 Б. Ховдлын диастолын үед
 В. Тосгуурын систолын үед
 Г. яТосгуурын диастолын үе
5. Ховдлын систолын үед буруу ойлголтыг сонго.
 А. Ховлын бүлЧин агшина.
 Б. Хоёр болон гурван хавтаст хавхлаг хаалттай байна
 В. Тал саран хавхлаг онгорхой байна
 Г. Ховдлын бүлчин суларна.
6. Хоёр ба гурван хавтаст хавхлаг үед нээлттэй байна.
 А. Ховдлын систолын хувьд
 Б. Ховдлын диастолын үед
 В. Тосгуурын диастолын үед
 Г. Ховдол болон тосгуурын диастолын үе
7. Арьсны нэг хэсэгт шалбархай үүсвэл эхлээд ямар процесс явагдах вэ?
 А. Ялтасны тусламжтай цус бүлэгнэнэ.
 Б. Улаан эсийн тусламжтай хүчилтөрөгчийн зөөвөрлөлт нэмэгдэнэ.
 В. Цагаан эсийн тусламжтай нян бактерийг устгах нь нэмэгдэнэ.
 Г. Сийвэнд эсрэг биеүүд лоноор үүснэ.
8. Зурагт хүний зүрхний бүтцийг харуулжээ.



А. А болон В тасалгааг нэрлэнэ үү.

А

В [2]

В. Зургийг ашиглан С цусны судас артери, венийн судасны аль нь болохыг олж тогтооно уу.

Судасны төрөл

.....

Шалтгаан.....

.....

Ямар цус зөөдөг[3]